



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/407

Арвайхээр

**Цэргийн бэлтгэл албаны сургалт явуулах
тухай**

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Засгийн газрын 2002 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах журмын 4.5.3 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2019 оны н/01 дүгээр тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2019 оны мн/12 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн бэлтгэл офицер, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэнтэй явуулах цэргийн бэлтгэл албаны сургалтыг 2019 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс 7 дугаар сарын 5-ны хооронд зохион байгуулсугай.

2. Батлан хамгаалах яамны төсвөөс хуваарилагдсан бэлтгэл офицер, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтын зардал болох 7.094.740 (долоон сая ерэн дөрвөн мянга долоон зуун дөч) төгрөгийг төсвийн дагуу зарцуулж, санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д, зөвшөөрсүгэй.

3. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бэлтгэл офицер, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэнтэй явуулах сургалтыг заагдсан хугацаанд нь сахилга зохион байгуулалттай явуулж дүнг 2019 оны 7 дугаар сарын 8-ны дотор илтгэхийг Цэргийн штабын дарга (хурандаа М.Дэлгэрсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА-



Г.ГАНБОЛД

011100670